

**2017 ОНЫ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛД БОЛОН ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН
ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ӨГӨХ САНАЛ**

2016.12.02

Сүхбаатар сум

**Илтгэгч нь: Аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа**

Аймгийн ИТХ-ын төлөөлөгч та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Сэлэнгэ аймгийн Аудитын газар нь Монгол улсын Төрийн аудитын тухай хуулийн 15.2.4-д *"Орон нутгийн төсвийн төсөлд болон төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар санал боловсруулж аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд оруулах"* гэж заасан аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн 2017 оны төсвийн төсөлд санал, дүгнэлт боловсруулан танилцуулж байна.

Бид аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн төсвийн төсөл нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 57 болон 58 дугаар зүйлийн 58.2 -д заасан нөхцөл, чиг үүргийг хангасан эсэх, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан *"Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"*, аймгийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох бусад хууль эрх зүйн актуудтай нийцэж буй эсэх, төсвийн орлого, зарлагыг тайлант жилийн нөхцөл байдалд үндэслэн бодитоор төлөвлөсөн эсэхэд дүн шинжилгээ хийж, санал дүгнэлт боловсруулахыг зорьсон болно.

Нэг. Орон нутгийн төсвийн төслийн талаар

Сангийн яамнаас Сэлэнгэ аймгийн 2017 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг **14,433.6 сая** төгрөгөөр, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг **3,044.2 сая төгрөгөөр**, суурь зарлагыг **17,477.8 сая** төгрөг байхаар буюу алдагдалгүй байхаар хянаж ирүүлсэн байна.

Тусламжийн орлогоор орон нутгийн хөгжлийн санд **3,175.8 сая** төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэгт **44,665.7 сая** төгрөг хуваарилагджээ.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчаас өргөн мэдүүлсэн төсвөөр Сангийн яамнаас хянаж ирүүлсэн нийт орлого, зарлагыг **456,5 сая** төгрөгөөр нэмэгдүүлэн төсөвлөсөн байна.

Аймгийн ТЕЗ- нь төсвийн төсөл боловсруулахдаа “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7.1-д заасан шаардлагуудыг хангасан боловч зураг, төсөв, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх, Сангийн яамнаас хянагдаж ирсэн орлогыг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэх, нэмэгдэж төлөвлөсөн орлогын ихэнхийг аймгийн ИТХ-ын урсгал зардлуудыг санхүүжүүлэхээр өргөн мэдүүлж батлуулах, төсвийн жилийн дундуур үндэслэлгүй өсгөн төлөвлөсөн орлого биелэгдэхгүйд хүрвэл уг орлогоос санхүүжигдэхээр төлөвлөгдсөн урсгал зардлуудыг бус хууль тогтоомжийн хүрээнд зайлшгүй гүйцэтгэгдэх бөгөөд эх үүсвэр нь бүрдсэн байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал, хөрөнгө оруулалтын зардлуудыг танаж, тодотгох зэрэг зөрчил давтагдахаар төлөвтэй байна.

Хоёр. Төсвийн орлогын төлөвлөлтийн талаар:

2017 онд Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг Сангийн яамнаас **11,788.6 сая** төгрөгөөр төлөвлөн хянаж ирүүлсэн нь 2016 оныхоос 18,8 хувиар буюу **2,137.1 сая** төгрөгөөр буурсан байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчаас өргөн мэдүүлсэн төсвөөр Сангийн яамнаас хянаж ирүүлсэн нийт орлогоос усны төлбөрийн орлогыг 331,6 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг 40,0 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлогыг 30,0 сая төгрөгөөр, нэр зааж ангилагдаагүй орлогыг 29,3 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 22,5 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогыг 3,1 сая төгрөгөөр гэх мэтчилэн нийт **456,5 сая** төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Сангийн яамнаас хянаж ирүүлсэн орлогыг нэмэгдүүлэхээр өргөн мэдүүлсэн 456,5 сая төгрөгийн 72,6 хувийг зөвхөн усны орлого эзэлж байна.

Усны төлбөрийн орлого 2015 онд 495,0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 153,5 сая төгрөгөөр тасарч, 2016 оны ХБГ-ээр 337,4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 132,5 сая төгрөгөөр тасрах төлөвтэй байгаа бөгөөд энэ нь өмнөх жилүүдэд Сангийн яамнаас хянагдаж ирсэн усны төлбөрийн орлогыг аймагт үндэслэлгүйгээр өсгөн баталснаас төлөвлөгөө тасарч байсныг харуулж байна.

Гэтэл 2017 онд мөн л усны төлбөрийн орлогыг 2016 оны ХБГ болох 337,4 сая төгрөгөөс 116.8 хувиар, Сангийн яамнаас хянагдаж, УИХ-аар батлагдаж ирсэн 400,0 сая төгрөгөөс 82.9 хувиар тус тус өсгөж, өмнөх жилүүдэд гарч байсан

алдааг давтан 731,6 сая төгрөгөөр төлөвлөсөн нь бодит тооцоо судалгаагүй, үндэслэлгүй төлөвлөлт болсон байна гэж үзэж байна.

Хэрэв 2017 оны төсвийн жилийн явцад усны орлого нэмэгдэх нөхцөл байдал үүсвэл тухайн үед нь тодотгол хийж, холбогдох зардлыг санхүүжүүлэх хууль, эрх зүйн үндэслэл бүрэн байгаа учир уг орлогыг хууль, эрх зүйн үндэслэлгүйгээр өсгөж төлөвлөхгүй байх санал оруулж байна.

Улс, орон нутгийн төсвийн 5,390,0 сая төгрөгийн эх үүсвэрээр санхүүжигдсэн, 4,092.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, зарцуулалт, хяналтын эрсдэл үүссэн, төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт, аймаг, орон нутгийн удирдах албан тушаалтнуудын хамгийн хариуцлагагүй үйлдлийн жишээ болсон бөгөөд аймгийн Аудитын газраас аймгийн ИТХ-д байнга сонордуулж байдаг “ Аймаг хөгжүүлэх сан “-гийн орлого, зарлагыг орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэн болгон батлуулахаар өргөн мэдүүлээгүй байна. Иймээс уг сангийн орлого зарлагыг орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгон баталж, авлага барагдуулалт, орлого, зарлагын хөдөлгөөнд аймгийн ИТХ-ын зүгээс хяналтаа бүрэн хэрэгжүүлж байх саналыг оруулж байна.

Гурав. Төсвийн зарлагын төлөвлөлтийн талаар

Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсөвт байгууллагуудын ирэх 2017 оны нийт зарлагын төлөвлөгөөг Сангийн яамнаас **62,674.1 сая** төгрөгөөр хянаж ирүүлснийг 456,5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн **63,130.6 сая** төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд төсвийн зарлагын дүнд урсгал зардал 99,2 хувь, хөрөнгийн зардал 0,8 хувийг эзэлж байна.

Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсвийн зарлагыг аймгийн ИТХ-д **392,3 сая** төгрөгөөр, аймгийн Засаг даргад **62,738.3 сая** төгрөгөөр зэрэг нийт **63,130.6 сая** төгрөгөөр тооцсон байна. Орлогыг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор аймгийн ИТХ-ын урсгал зардлыг 242,6 сая төгрөгөөр, аймгийн ЗДТГ-ын зардлыг 124,1 сая төгрөгөөр, Орон нутгийн өмчийн газрын зардлыг 4,0 сая төгрөгөөр, гэрэлтүүлгийн зардлыг 4,6 сая төгрөгөөр, сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 105,5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, Санхүүгийн хяналт аудитын албаны зардлыг 24,3 сая төгрөгөөр бууруулснаар нийт дүнгээр зарлагыг **456,5 сая** төгрөгөөр нэмэгдүүлэхээр өргөн мэдүүлжээ.

Аймгийн төсвийн 2017 оны төсвийн зарлагатай холбоотой, хууль тогтоомж зөрчсөн дараах зарцуулалтыг нарийвчлан авч үзэж, хэлэлцэн батлах саналыг төлөөлөгч та бүхэнд хүргэж байна. Үүнд:

1. Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тушаалаар Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг

дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг байхаар тогтоож, бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээг баталсан байдаг боловч уг зардалд аймгийн ОНХС-аас 50,0 сая төгрөг зарцуулахаар тусгасан байна.

2. Усны орлогыг үндэслэлгүйгээр хий өсгөн төлөвлөсөнтэй холбоотойгоор Сангийн яамнаас хянагдаж ирсэн аймгийн ИТХ-ын урсгал зардлыг 242,6 сая төгрөгөөр буюу 2,6 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна.

УИХ-ын “ Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2016 оны 47 дугаар тогтоолоор төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр дараах арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч нарт үүрэг болгосон байна. Үүнд:

- Байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах зэргээр орон тоо, цалин хөлс, урсгал зардлыг бууруулах, ,
- Гадаад томилолтын зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй байх,
- Эмнэлгийн түргэн тусламж, онцгой байдал, авлигатай тэмцэх, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, прокурор, цагдаагийн эргүүл хамгаалалт, шүүхийн шинжилгээний алба, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, хил хамгаалах, батлан хамгаалах салбарын байгууллагаас бусад бүх шатны төсвийн байгууллага албан ажлын хэрэгцээний тээвэр, шатахуун, сэлбэг хэрэгсэл, үйлчилгээний бусад зардлыг бууруулах;

Гэтэл төсвийн төлөвлөлт, зарцуулалтад хяналт тавих чиг үүрэг бүхий аймгийн ИТХ -ын ажлын албаны орон тоог 2 хүнээр нэмэгдүүлэн, дотоод албан томилолтын зардлыг 2,1 дахин, урсгал засварын зардлыг 3,6 дахин, тээвэр шатахууны зардлыг 4,6 дахин, хуралдааны зардлыг 7,7 дахин өсгөн, хянагдсан төсөлд тусгагдаагүй байсан гадаад албан томилолт, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, орон нутгийн нөөц хөрөнгө, зочид төлөөлөгч хүлээн авах зардлуудад 5,0-10,0 сая төгрөгийг нэмж тусгасан учир эрхэм төлөөлөгчид та бүхнийг төрийн хууль, тогтоомж, төсөв санхүүгийн талаар баримталж буй бодлогыг өөрөөсөө эхлэн хэрэгжүүлж, нэмж төлөвлөхөөр өргөн мэдүүлсэн дээрх зардлыг хасч батлах санал оруулж байна.

3. Зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл, зах зээлийн үнэ ханшийн судалгаа хийгдээгүй аймгийн нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн тасгийн барилга худалдан авахад 200,0 сая төгрөг, Түнхэл тосгоны сургуулийн сурагчдын дотуур байр худалдан авахад 200,0 сая төгрөг зэрэг нийт **400,0 сая** төгрөгийн худалдан авалтыг ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасан байгаа нь худалдан авах барилга, байгууламж, түүний үнэ ханшийг урьдчилан тохирсон мэт харагдуулж, худалдан авах

ажиллагааны хууль тогтоомжийг зөрчихөд хүргэж болзошгүй нөхцөл байдлыг үүсгэж байна. Иймээс уг худалдан авалт, түүний үнэ ханшийн судалгааг хэлэлцэн, батлах саналыг оруулж байна.

4. Болд төмөр- Ерөө гол компанийн 95,0 сая төгрөгийн хандив тусламжийн эх үүсвэрээр 2015-2016 оны төсвийн жил дамжин Сүхбаатар суманд баригдсан хөлбөмбөгийн талбайн ажил чанаргүй хийгдсэн, ашиглагдах боломжгүй гэж үзэн ОНХС-гийн 327,0 сая төгрөгийн санхүүжилтээр цэнгэлдэх хүрээлэнгийн саравчийг гүйцээж, хөл бөмбөгийн талбай байгуулахаар төлөвлөж байгаа нь төсвийн хөрөнгийн эх үүсвэр хангалтгүй байгаа өнөөгийн нөхцөлд үр ашиг, байнгын ашиглалт, хүртээмжтэй зардал мөн эсэхийг анхааран үзэх санал оруулж байна.
5. Сүүлийн жилүүдэд аймаг сумдын ОНХС-гийн болон хөрөнгө оруулалтын зардлын санхүүжилтээр сумдын зам засвар, тэмдэг тэмдэглэгээний ажилд тогтмол хөрөнгө төлөвлөн хэрэгжүүлж ирсэн байхад Замын сангийн 340,0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг хэт жижиглэн сум бүрт 20,0 сая төгрөг олгохоор төлөвлөн өргөн мэдүүлсэн байна. Сум тус бүрт хуваарилсан 20,0 сая төгрөг нь замын чанарт онцын эерэг нөлөө үзүүлж чадахгүй, үр ашиггүй, насжилт багатай зарцуулалт болох учир дээрх 340,0 сая төгрөгийн эх үүсвэрээр цөөхөн ч гэсэн үр ашиг, ашиглалт, насжилт өндөр байх замын ажил санхүүжүүлэх боломжийг тооцон үзэх санал оруулж байна.

Эрхэм төлөөлөгчид өө, төсвийн хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалт нь хууль эрхийн актад нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, нийтэд хүртээмжтэй, нийгмийн ач холбогдолтой байхыг иргэд, олон нийт шаардан, хүлээж байгаа өнөөгийн нөхцөлд та бүхнийг аймгийн 2017 оны төсвийн орлого, зарлагыг төлөвлөж, батлах хариуцлагатай албаа Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль эрхийн актууд, нийтийн эрх ашигт нийцүүлэн хэрэгжүүлэхийг хүсэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

